



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/116

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын хурлын тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар албан даалгавар, Засгийн газрын хөдөө аж ахуйн бэлтгэл хангах тухай 2020 оны 69 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нөөцийн 2020-2021 оны өвс бэлтгэлээр борлуулагдах явцад задарч, бутарсан өвсийг прессэлж дахин борлуулалтанд оруулахад зарцуулах 304000 төгрөгийг олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 304000 төгрөг /гурван зуун дөрвөн мянган/-ийг аймгийн өвс, тэжээлийн нөөцийн санхүүжилтээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/116 Ch

02 0705